

### 2.13. БОЛОВСРОЛ БОЛ ТАНИН МЭДЭХҮЙ МӨН ТУХАЙ ФИЛОСОФИ ЗАРИМ ҮНДЭСЛЭЛ

*Түлхүүр үг: Боловсрол, Мэдлэг, Утопи, Фантази, Миф*

Боловсрол бол маш олон тал бүхий үйл явц болохыг судлаачид тэмдэглэж иржээ. Энэ талаархи жинтэй судалгаануудаас нэгийг цохон дурдахыг зүйтэй гэж үзэж байна. Үүнд: Оросын Боловсролын академийн академич, доктор Б.С.Гершунский "ХХ зуун руу чиглэсэн боловсролын философи" нэртэй томоохон бүтээлийг 1998 онд хэвлүүлжээ. Тэрээр энэ номондоо боловсролын агуулгыг дор хаяж 4 талаас (асpekтаас) үзэж болно гэжээ. Тэдгээр нь:

- Боловсрол бол үнэлэмж мөн;
- Боловсрол бол тогтолцоо(систем) мөн;
- Боловсрол бол үйл явц (процесс) мөн;
- Боловсрол бол үр дүн (результат) мөн

гэсэн 4 талыг онцлоод улмаар тэдгээр тал бүрийн онцлогийг дэлгэрэнгүй тайлбарласан байна.<sup>1</sup>

Энэ ангилалд боловсролын агуулгын олон чухал талыг зүйтэй илэрхийлснийг тэмдэглэхийн сацуу түүнд "боловсрол бол танин мэдэхүй мөн" гэсэн нэг бүрэлдэхүүн нэммээр санагдав.

Б.С.Гершунский боловсрол бол тодорхой чиглэлээрээ танин мэдэхүй мөнийг үгүйсгээгүй байна. Ингэхдээ тэрээр ийм үйл ажиллагааг "боловсрол бол үйл явц мөн" гэж үзэж байгаадаа багтаасан байна. Бидний хувьд боловсролыг танин мэдэхүй мөний хувьд яагаад бие даалган онцолж буй шалтгаанаа эхлээд дурдъя. Үүнд, нэгдүгээрт, боловсрол бол мэдлэг мөний хувьд түүнийг бүрдүүлдэг маш чухал агуулгат хэсгүүд нь үнэлэмж, танин мэдэхүй хоёр мөн. Иймд боловсрол бол үнэлэмж мөнийнх нь бие даасан ач холбогдлыг дурдсан байтлаа танин мэдэхүйн талд нь тэгэж хандахгүй бол агуулга, арга зүйн хувьд учир дутагдалтай санагдаж байна. Хоёрдугаарт, боловсрол бол үйл явц мөний хувьд өөрийнхөө хүрээнд бас нийлмэл олон бүрэлдэхүүнтэй бөгөөд тийм олон бүрэлдэхүүн, дэд тогтолцоонд танин мэдэхүй бол олон нөхцөлд тодорхойлогч элемент нь болж өгдөг гэж бид үзэж байна. Тийм



учраас боловсрол бол танин мэдэхүй мөн болохыг түүний (боловсролын) бие даасан нэг тал гэж үзэх нь зүйтэй санагдаж байна.

Боловсрол бол сургалт, хүмүүжил хоёрын нэгдэл мөн нь сурган хүмүүжүүлэх онол ба практикт аксиом болсон үндэслэл билээ. Тэгвэл сургалт, хүмүүжил хоёрын субъект, объект аль аль нь танин мэдэгч мөн.

Сургалт, хүмүүжил хоёрын субъект маш олон янзын хүрээ бүхий байдаг ба түүний хамгийн өргөн хүрээ нь хүн төрөлхтөн юм. Үүнд, хүн төрөлхтөн бол байгалийг, байгалийн биш зүйлийг (тухайлбал бурхан тэнгэрлэг зүйлийг), өөрийгөө ч танин мэдэж, төлөвшүүлэгч субъект болж байдаг. Тэрчлэн түүхэн тодорхой нийгэм бүхэн боловсролын субъект болж, бас тэдгээр тус бүрийн дотоод дахь янз бүрийн түвшний (удирдлага, анги давхраа, хамт олон, гэр бүл зэрэг) хүмүүсийн нийтлэг ба бодгаль хүн тус бүр боловсролын субъект болж, энэ бүгд нь сургалт, хүмүүжлийн үйл явцыг, бүхэлтгэн хэлбэл боловсролын үйл ажиллагааг өөр өөрийн хэрэгцээ, зорилгонд хэрэгжүүлж байдаг билээ.

Боловсролыг танин мэдэхүй гэж онцолж буй нөхцөлд түүний бүрэлдэхүүнүүд дотроос сургалтыг тодорхойлогч бүрэлдэхүүн хэмээн онцолж үзэх шаардлагатай байдаг. Ийм байр суурины үүднээс боловсролын субъектүүдийг авч үзэхдээ нэн түрүүнд сургалтын субъектыг онцлох нь зүйтэй юм.

Сургалтын ийм олон янзын түвшин ба хүрээний субъектууд дотор багш хүн онцгой үүрэгтэй байдаг нь ойлгомжтой. Тийм учраас зарим судлаач “багш” гэдэг үгийг өгүүлбэрийн дотор том үсгээр эхлэн бичсэн нь дайралддаг. Энэ нь христос шашны зарим бүтээлд “бурхан тэнгэр(god-бог)” гэдэг үгийг том үсгээр бичдэг шиг, мөн экзистенциализмын зарим төлөөлөгч ахуйг тодорхойлогч субъект мөний нь хувьд “бие (ego)” гэдэг нэр үгийг том үсгээр эхлэн бичсэн байдаг шиг дээдэлсэн утгатай байдаг байна. Үнэхээр ч Багш бол орчин үеийн зориулалтаараа бэлэн мэдлэг дамжуулагч төдий биш болж хувирчээ. Орчин үеийн Багш бол аль нэг сонгосон сурах бичиг, сургалтын албан ёсны материалд сэтгэл ханалгүйгээр тэдгээрт нэн шүүмжлэлтэй, бүтээлчээр хандах шаардлагатай болсон ба энэ нь ч олон шалтгаантай болсон байна. Тухайлбал орчин үед:

- Мэдлэг маш хурдан өсдөг болсон учраас өчигдрийн үнэнд засвар оруулсан шинэ нээлт, ололт өнөөдөр гарах нь ховор биш үзэгдэл болж хувирсан тийм нөхцөлд бид амьдарч байна.



- Мэдлэг олж авах хэрэгсэл нэн олон янз болжээ
- Дэлхийн үйл явцад даяаршил чухал ач холбогдолтой болж, том бага улс гүрнүүдийн харилцан хамаарал өргөжин гүнзгийрч байгааг мэдэрч, түүнийгээ сургалтанд цаг алдалгүй идэвх, санаачлага гарган харгалзах хэрэгцээ боловсролын практикт өсөж байна. Дээрээс заавар, зөвлөмж ирэхийг хүлээвэл нийгмийн өөрчлөлтийн цагт хавчигдаж болох тохиолдол сургалтын практикт олон гарах болов.

Үүний зэрэгцээ даяаршлын нөхцөлд улс орон бүр өөрийн бие даасан бүрэн эрхт байдлаа, олон улсын тавцанд эзэлж буй байр сууриа хадгалан бэхжүүлэхийн ач холбогдлоо мэдэрдэг байх нь сургалтанд үндэсний хүчин зүйлсийг тусгадаг байх танин мэдэхүйн, ёс зүйн болон сэтгэл зүйн нэн чухал хүчин зүйл болж байна.

Мөн нийгмийн амьдрал объектив хүчин зүйлсээр болон субъектив янз бүрийн үйлдлээр нөхцөлдөн дэвшилтэт ба ухралтат янз бүрийн өөрчлөлтөнд байнга орж байдаг нь багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд хамаагүй зүйл огтхон ч биш билээ.

Эдүгээ үеийн сургалт зөвхөн аль нэг шинжлэх ухаанд зориулагдах биш, харин олон шинжлэх ухаан, мэдлэгийн өөр өөр төрлийн сэдвүүдийг синтезлэн авч үзэх байдал болж хувирах хандлага руу орж байгаа ажээ.

Сургалтын арга барилд менежментийн онолын үр шим, орчин үеийн технологийн ололт улам бүр нэвтэрч байна.

Товчоор хэлбэл орчин үед багш хүн, ер нь сурган хүмүүжүүлэгчид бүхэлдээ зөвхөн сурган хүмүүжүүлэх болсон хичээл заах сэдвийнхээ дагуухь бэлэн мэдлэг эзэмшсэн хүн төдий биш, харин улс орныхоо дотоод ба гадаад, онолын ба практикийн хурц хурц асуудлыг мэдэрч, тэдгээрт өөрийн гэсэн үнэлгээ өгдөг, дэлхийн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийн ололттой танилцсан, тэр бүгдээ сургалтын үйл ажиллагаандаа харгалздаг хүн байх ёстой тийм үе болжээ.

Сургалтын субъект нь ийм бүтээлчээр танин мэдэгч болж байгаа нь сургалтын объектийг хөгжүүлэх, тухайлбал суралцагч нар сургалтын явцад мэдлэгийг бүтээлчээр идэвхтэй, үйлдэлдээ ашигтай эзэмших нэн чухал нөхцөл болж байна.

Өөрөөр хэлбэл боловсрол бол танин мэдэх үйл ажиллагаа мөн болохын хувьд суралцагчдад мэдлэг өгөх төдий үйл ажиллагаа биш, харин асуудал дэвшүүлэх,



шийдвэрлэх, шийдвэрийн зохистой ба боломжтой хувилбаруудыг илрүүлэх үйл ажиллагаа байх ёстой. Энэ бол тухайн мэдлэг агуулгын хувьд багшид бэлэн байлаа гэхэд түүнийг суралцагчдад эзэмшүүлэх болон амьдрал, практикт ашиглах хэрэгсэл болж өгөх бололцооны хувьд шинэ асуудал, сайн шийдлийн хэлбэр, маягтай байх ёстой гэсэн үг мөн. Тийнхүү сургалт монизмд биш, харин плюрализмд; абсолютизмд биш, харин релятивизмд үндэслэж, бас тэр нь зөвхөн хийсвэр онолын зарчимтай биш, бас амьдрал, практик туршлагын мэдлэгтэй холбогддог байх ёстой. Чухам ийм нөхцөлд боловсрол өөрийн танин мэдэх функцийг агуулгын хувьд үнэн ба практик үйлдэлд үр ашигтай хэрэгжүүлэх бололцоотой байх юм.

Боловсрол бол танин мэдэхүй мөний хувьд хүн төрөлхтний рациональ (оюуны) үйл үү, эсвэл иррациональ (мэдрэмжийн) үйл үү гэдэг асуудлыг философийн янз бүрийн чиглэлийн төлөөлөгчид өөр өөрөөр шийдвэрлэж иржээ. Тухайлбал Гегель сэтгэхүй, ахуйн адилслын зарчим боловсруулсан нь тэрээр танин мэдэхүйг эцсийн эцэст рационализмийн үүднээс шийдвэрлэснийг илэрхийлдэг философи зарчим мөн. Үүнд, сэтгэхүйг судлаад илрүүлсэн аливаа хууль, зарчим бол дашрамдаа ахуйн хууль, зарчим болдог гэсэн философи үзлийг тэрээр боловсруулсан ажээ.

Диалектик материализмыг үндэслэгч К.Маркс, Ф.Энгельс нар хэдийгээр рационализм, иррационализм хоёрыг аль алиныг нь ерөөсгөл шинжтэй хэмээн шүүмжилдэг байсан ч хэрэг дээрээ рационализмыг баримталдаг байсан гэж үзэх үндэстэй юм. Энэ нь марксист-ленинист философи хүн төрөлхтний танин мэдэхүйг "мэдэрч танин мэдэхүй", "сэтгэж танин мэдэхүй" гэж хоёр хувааж, ингэхдээ мэдэрч танин мэдэхүйг нь танин мэдэхүйн доод шат, харин сэтгэж танин мэдэхүйг нь танин мэдэхүйн дээд шат мөн хэмээн тайлбарладаг байсанд илэрдэг билээ.<sup>2</sup> Ийм үзлийн философи арга зүйн үндсийг К.Маркс, Ф.Энгельс, В.И.Ленин нар тавьсан ажээ. Тухайлбал К.Маркс "Фейербахын тухай сэдвүүд" хэмээх тэмдэглэлдээ "... Фейербах хийсвэр сэтгэхүүд сэтгэл таашаалгүй, мэдрэн ажиглахууд горьдлого тавьжээ, тэгэхдээ мэдрэхүйг хүний *практик* үйл хэмээн үзсэнгүй"<sup>3</sup> гэж түүний сенсуалист байр суурийг шүүмжилсэн байдгаас гадна "... практик дээр хүн өөрийн сэтгэхүйн үнэнтэй, өөрөөр хэлбэл бодитой хийгээд чадалтай, янагуухь болохыг батлан үзүүлэх ёстой"<sup>4</sup> хэмээн танин мэдэхүй, түүний үр дүн болдог үнэний асуудлыг практикт холбогдох асуудал гэж үзсэн байна.



Ф.Энгельс ч гэсэн ийм арга зүйн үүднээс сэтгэхүйг, тэр дундаас диалектик сэтгэхүйг жинхэнэ танин мэдэхүй гэж үзэж байв.<sup>5</sup>

Мөн В.И.Лениний "Философийн дэвтрүүд" нэрээр хэвлэгдсэн философийн сэдвээрх янз бүрийн тэмдэглэл, дуусгаагүй ноорог зэргийн эмхтгэлээс бүтсэн боть зохиолд: шинжлэх ухааны бүх (зөв нухацтай, хуурмаг биш) хийсвэрлэлүүд байгалийг улам гүн, улам үнэн, илүү бүрэн тусгадаг. Тулж ажиглахаас хийсвэр сэтгэхүйд, түүнээсээ практикт орох нь объектив бодит байдлыг танин мэдэх диалектик зам мөн<sup>6</sup> хэмээн бичсэн байдаг билээ. Тийнхүү В.И.Ленин марксист философийн нэг гол төлөөлөгч мөний хувьд сэтгэхүйг мэдрэхүйгээс буюу тулж ажиглахаас дээгүүр тавьжээ.

Гэхдээ марксизм танин мэдэхүйн онолд хэрэг дээрээ рационализмыг баримталсан нь боловсролын онол дахь түүний тодорхой эерэг ач холбогдлыг үгүйсгэх гэсэн зорилгогүй билээ. Тухайлбал энэ сургаал сургалтанд онол, практикийн нэгдлийг хангахын чухлын тухай зорилгын хувьд зүйтэй асуудал дэвшүүлдэг. Гэвч энд сургалт, хүмүүжил хоёрын субъект, объект аль алины хувийн амьдралын онцлог, хувийн мэдрэмж зэргийг харгалзахыг онолын хувьд орхигдуулдаг талтай. Энэ нь боловсрол дахь танин мэдэхүйн ба үнэлэмжийн үйл явцыг иррациональ талыг орхигдуулдгаас ихээхэн шалтгаалдаг байна.

Гэтэл XIX зууны сүүлийн хагасаас хойшхи Өрнөдийн философийн олон чиглэлд танин мэдэхүйг хүний иррациональ үйл ажиллагаа мөн гэж үзэх болсон билээ. Тухайлбал прагматизмын томоохон төлөөлөгч Дж.Дьюй шинжлэх ухаан бол үйлдэл хийхэд ашиг өгдөг багажнууд (категориуд) агуулсан хайрцаг (тогтолцоо) мөн гэж дүрслэн бичсэн нь зөвхөн шинжлэх ухааныг биш харин ерөөсөө түүнийг өөртөө багтаагч сэтгэхүйг бүхэлд нь гносеологийн хувьд иррационалист байрнаас тэрээр ойлгож байсны нэг гэрч юм гэж үзэх үндэстэй. Өөрөөр хэлбэл Дж.Дьюйгийн үзлээр хандвал шинжлэх ухааны мэдлэг бол үнэн байж тэр бүр чаддаг биш, тусгалын үр дүн биш, харин практик үйлдэл хийхэд ашгаа өгөх тийм мэдлэгийн тогтолцоо мөн.

Бидний хувьд танин мэдэхүй бол рациональ ба иррациональ аль аль тал бүхий байдаг бөгөөд энэ хоёрын аль нэгийг нь нөгөөгөөсөө давуу юм уу дутуу гэж үзэхийг буруу гэсэн байр суурь баримталж байна. Үүнд, танин мэдэхүйн рациональ тал буюу сэтгэхүй бол объектыг мэдрэхүйд өртөгдөөгүй байхад хүртэл (хүний хэл яриа, бусад тэмдэглэгээ, үйлдэл зэргээр дамжуулж) түүнийг (объектыг) танин мэдэж байдаг, нэг



төрлийн бүхэл юмсын нийтлэг шинжүүдийг илрүүлдэг, мөн тухайн нэг юм уу нэг төрлийн бүлэг юмны тухайн харьцааны үүднээс гол гол шинжийг нь илрүүлдэг олон давуу талтай.<sup>7</sup>

Гэвч сэтгэхүй бол гносеологийн хувьд дутагдал, өрөөсгөл байдлаас ангид биш болохыг философийн иррационализмын олон төлөөлөгч тэмдэглэж иржээ. Бүр XVIII зуунд, ялангуяа XIX зууны эхний 20-30-аад жилд, өөрөөр хэлбэл философи сэтгэлгээнд Р.Декарт, Б.Спиноза, Г.В.Гегель зэрэг онолчдын нөлөөгөөр рационализм маш хүчтэй нөлөө бүхий байсан тэр үед иррационализмын үзэл зэрэгцэн бий болж, улмаар тэр үеийн оюуны соёлын янз бүрийн (урлагийн онол, шашин, ёс зүйн онол зэрэг) төрөлд болон сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд арга зүйн хувьд өргөн нэвтрэх болжээ. Энд боловсролын үйл ажиллагаанд онцгой нөлөөлсөн анхан үеийн иррационалист зарим үндэслэлийг зохиогч нартай нь холбон дурдъя.

-Германы философич И.Г.Гаман /1730-1780/ Б.Спинозагийн рационализм, И.Кантын критицизм (шүүмжлэлт үзэл) хоёрыг үл зөвшөөрөөд: бодит байдлын тухай жинхэнэ мэдлэгийг бурхан тэнгэрлэг (мистик) туршлага (шашны мэдлэг), интуици зэргээр олж болохоос сэтгэхүйгээр олж авч болдоггүй. Яагаад гэвэл сэтгэхүй нь хэлэнд үндэслэдэг бөгөөд гэтэл хэл бол аугаа ойлголт (одоогийн хэллэгээр онолын ойлголт –С.Д.), өчүүхэн ойлголт (одоогийн хэллэгээр ердийн өдөр тутмын бодлын ойлголт) хоёрыг ялгахгүй байхын шалтгаан болдог зүйл мөн гэсэн юм.<sup>8</sup> Үнэхээр ч, жишээ нь "цахилгаан" гэсэн үг өдөр тутмын ярианд олон утгатайгаар хэрэглэгддэг бол энэ үг физикийн сургалтанд тогтсон чанд утга бүхий байх шаардлагатай нь ойлгомжтой.

И.Г.Гаманы эл үзлийг гүнзгийрүүлэн тайлбарласан сэтгэгчдийн нэг бол германы хэл шинжээч, нэрт соён гэгээрүүлэгч, сурган хүмүүжүүлэх ухааны томоохон зүтгэлтэн, бас томоохон зохион байгуулагч В.фон Гумбольдт /1767-1835/ юм. Тэрээр Гегелийн рационализмыг үл зөвшөөрөөд: хэл бол субъект, объект хоёрыг, мөн хүн, ертөнц, бурхан тэнгэр гурвыг шууд зуучлагч мөн гэж сурталчилсан байдаг. Тэгээд эндээсээ: сэтгэхүй, бодит байдал хоёр шууд холбогддоггүй бөгөөд учир нь тэдгээрийн хооронд хэл /хөндлөнгөөс орж ирэх, зуучлах зэргээр/ заавал байдаг. Тийнхүү сэтгэхүй бол бодит байдалд тохирох бололцоо байхгүй юмуу хязгаарлагдмал байдаг гэж В.фон Гумбольдт үзсэн нь иррационалист хандлага юм.<sup>9</sup>



- Германы философич Ф.Г.Якоби бишрэл, мэдрэмж хоёроос төрдөг мэдлэгийг дээдлэн, тэдгээрийн үр дүнг "оюун ухаан" гэж нэрлэж, харин сэтгэхүйг доод мэдлэг өгдөг гэж үзээд түүнийг "оюун бодлын сэтгэхүй" гэж нэрлэж байжээ. Тэгээд тэрээр: амьдрал оюун ухааныг агуулдаг болохоос оюун ухаан амьдралыг агуулдаггүй. Амьдрал, түүний эх сурвалж, уг чанар бидний оюун ухаанд нууц байдаг гэж бичсэн байна.

Амьдралыг бидний оюун ухаан танин мэдэж тийнхүү дийлдэггүй тул оюун бодлын сэтгэхүй бүр ч дийлэхгүй гэж Якоби үзсэн нь ойлгомжтой.<sup>10</sup>

- Германы философич А.Шопенгауэр /1788-1860/ "оюун ухаан", "оюун бодол" гэдэг нэр томъёог Ф.Г.Якобигоос эсрэг үнэлэмжтэй ашигласан байна.Үүнд, түүний хувьд оюун ухаан бол "сэтгэхүй" гэсэн утгатай, харин оюун бодол бол "мэдрэхүйн үр дүнг боловсруулсан мэдлэг" гэсэн утгатай байдаг.Энд оюун ухаан бол зөвхөн хүнд байдаг учраас оюун бодлоос хязгаарлагдмал, тэгээд бас хүний хүсэл эрмэлзлийг хаан боогдуулж, хүний үйлдлийг жолоодож байдаг. Гэтэл хүн, ахуй аль алины эхлэл нь үл танигдагч хүсэл эрмэлзэл байдаг. Өөрөөр хэлбэл хүнийг, түүний ахуйг буюу амьдралыг жолоодогч нь оюун ухаан (сэтгэхүй) биш, харин хүсэл эрмэлзэл (оюун бодол) байдаг гэж А.Шопенгауэр үзсэн байна.<sup>11</sup>

- XX зуунд иррационализм маш олон (амьдралын философи, экзистенциализм, феноменологи, шашны философи, постмодернизм гэх мэт) чиглэлээр дэлгэрч ирсэн байна. Тэдгээр дэх хоёр нийтлэг санааг дурдвал: нэгдүгээрт, тэдгээрийн үнэлгээгТр сэтгэхүй бол юмсын өвөрмөц шинж, талуудыг орхигдуулсан хавтгай мэдлэг бий болгодог дутагдалтай. Ийнхүү тэдгээр чиглэлүүд сэтгэхүй нь онолын түвшинд янз бүрийн категори, хууль, зарчим боловсруулдгийг үл ойшоодог. Хоёрдугаарт, сэтгэхүйгээр, ялангуяа шинжлэх ухаанаар бий болдог мэдлэг хүн төрөлхтнийг мөхөл рүү түлхдэг хэмээн тэдгээр нь үздэг байна.

Угтаа хүний сэтгэхүйд, түүний дээд хэв маяг болох онолын сэтгэхүйд, тухайлбал шинжлэх ухаанд дээр дурдсан маягийн сөрөг үр дагаврууд ялангуяа XIX зууны сүүлийн хагасаас хойш гарах болсон нь үнэн билээ.Чухам энэ нь тухайлбал бихевиоризм, фрейдизм, неофрейдизм зэргийн "инстинктив дур хүсэл (либидо)", инстинктив түлхээс, инстинктив догдлол (эмоци) гэх мэт үзэл санаа өрнөдийн сургалт, хүмүүжлийн практикт өргөн нэвтрэхэд түлхэц болжээ гэх үндэстэй юм.



Гэвч энд нэг зүйлийг нэмж хэлэх шаардлагатай санагдаж байна. Үүнд, хүний оюун ухааны мэдлэг, түүний дотор шинжлэх ухааны мэдлэг бол танин мэдэхүйн үр дүн мөний хувьд туйлын үнэнд хүрдэггүй ч гэсэн ахуйн нууц руу улам бүр нэвтэрч байдаг билээ. Түүнчлэн шинжлэх ухааны мэдлэг хүн төрөлхтний эсрэг ашиглагддаг нь түүний (шинжлэх ухааны) буруу биш, түүнийг хортойгоор ашиглагчдын буруу байдаг.

Танин мэдэхүйн онолын салбарт рационализм, иррационализм хоёр тийнхүү өрсөлдөн оршиж, үр дагавар нь боловсролын үйл ажиллагаанд нөлөөлж ирсэн бөгөөд энэ тухай өмнө нь ч бас цухас дурдсан билээ.

Ер нь боловсролын үйл ажиллагаанд рациональ (оюунлаг) ба иррациональ (мэдрэмжийн, иймд үнэлэмжийн) зарчим аль аль нь харилцан уялдаж, бие биеэ сэлбэж байдаг гэж болно. Үүнийг боловсролын тогтолцооны бүх түвшинд хамруулан дурьдаж болох юм. Ялангуяа дээд боловсролын тогтолцоонд энэ нь илүү холбогдох нь лавтай. Ингэж үзэж байгаатайгаа уялдуулан оросын философич Н.В.Карловын "Вопросы философии" сэтгүүлд хэвлүүлсэн "Боловсролыг өөрчлөхүй" нэртэй өгүүлэлд "... орчин үеийн хүн боловсролыг дээд сургуулиас салгаж бодохоо больжээ. Дээд сургуулийн хэв шинжит төлөөлөл бол Гумбольдтын хэв маягаар боловсрол, судалгаа хоёрыг хослуулдаг орчин үеийн их сургууль мөн"<sup>12</sup> гэж өгүүлжээ. Тийнхүү дээд боловсрол бол зүгээр нэг мэдлэг эзэмшихүй, хүмүүжихүй төдий биш, харин танин мэдэхүй (судалгаа) юм гэдгийг энэ өгүүллэгийн зохиогч Гумбольдтын үзэл санааны дагуу онцолжээ.

Гэхдээ Л.фон Гумбольдт: судалгаа бол зөвхөн сэтгэхүйн, шинжлэх ухааны эрэл хайгуул биш гэж үзэж байсан юм. Түүний философидолтоор судалгаа бол шинжлэх ухааны сэтгэхүйгээс гадна хэлний хэрэглэгдсэн байдлыг олж тогтоохүй мөн. Ийнхүү судалгаа бол рациональ зүйл, иррациональ зүйл хоёрын нэгдэл мөн.

Эндээс: судалгааг өөртөө заавал багтаадаг дээд боловсрол, улмаар ерөнхийлөн хэлбэл боловсрол бүхэлдээ рациональ(оюунлаг) ба иррациональ (мэдрэх туршлагын ба үнэлэмжийн) үйл явцын нэгдэл мөн гэсэн дүгнэлт хийж болохоор юм.

Ийм гносеологи дүгнэлт угтаа шинэ зүйл биш бөгөөд тухайлбал оросын философич Л.П.Буява Оросын ШУА-ийн Философийн институт, Оросын Боловсролын Академи, "Вопросы философии" сэтгүүл гурваас хамтарч 1997 онд явуулсан дугуй



ширээний ярилцлаганд оролцож хэлсэн үгнээс харж болно. Тэрээр "... боловсролын үйл явцад соёл дахь оюуны үндэслэгээтэй янз бүрийн нөхцөл, аяндаа гарч ирдэг иррациональ, интуитив фантази хэлбэрүүд хоёр нэгдэлтэйгээр ба зөрчилтэйгөөр зэрэгцэн оршдог"<sup>13</sup> гэжээ.

Боловсролын үйл явц бол рациональ (оюунлаг) талтай нь монголчуудын хэвшмэл сэтгэлгээнд эргэлзээ төрүүлэхгүй зүйл билээ. Харин иррациональ тал сургалт, хүмүүжлийн ажилд хэрхэн илэрдэг нь манай олон хүнд тодорхойгүй байх үндэстэй. Учир нь сэтгэхүй бол мэдрэхүйгээс давуу гэсэн философи үзэл олон арван жилийн турш баримтлагдаж ирсэн манай нөхцөлд рациональ ба иррациональ танин мэдэхүйг боловсролын үйл ажиллагаанд эн чацуу ач холбогдолтой хэмээн асуудлыг тавих нь цөөнгүй хүнд эргэлзээ төрүүлэх үндэстэй.

Үүнийг харгалзах үндсэн дээр тийм эргэлзээг арилгахын тулд иррациональ танин мэдэхүйн ямар ямар гол хэв маяг боловсролын үйл ажиллагаанд хэрэгждэг талаар товч авч үзье.

Л.П.Биева боловсролын үйл ажиллагаанд хэрэгждэг иррациональ хэлбэрүүд дотроос утопи, иллюзи, миф гурвыг зориуд дурджээ. Гэхдээ эдгээр иррациональ хэлбэр тус бүрийн онцлогийг тэрээр өгүүлээгүй юм. Ийм учраас эдгээр нэр томъёогоор зохиогч ямар санаа илэрхийлснийг тааж дурдмааргүй байна. Харин холбогдох зарим нийтлэлийг ашиглах үндсэн дээр уг гурван хэлбэр тус бүрт өөрийн товч тайлбар хийе. Эдгээр иррациональ хэлбэр тус бүртээ бие даасан шинжтэйн зэрэгцээ харилцан бие биендээ үндэс, нөхцөл, нэмэлт болж байдгийг урьдчилан дурдъя.

*Утопи.* "Утопи" гэдэг бол грек хэлний "байхгүй газар" гэсэн утга бүхий үгийг XVI зууны английн философич, Сэргэн мандалтын рационалист гуманист үзэлтэн Томас Мор гол зохиолынхоо нэрэнд оруулснаас үүдэлтэйгээр тэр нь нийгмийн сэтгэлгээний нэг чухал ойлголтын нэр болсон нь дунд сургуулийн сурагчдад ч гэсэн тодорхой билээ. Тодруулж дурдахад энэ үг ирээдүйд биелээсэй хэмээн мөрөөдсөн сайн сайхан нийгмийн тухай үзлийн нэр болж нийгмийн сэтгэлд хэвшсэн байна. "Утопи" гэдэг нэр томъёо явцуу утгаараа нийгмийн амьдралын аль нэг салбар, хүрээний ирээдүйн хандлагын тухай зөгнөлийн нэр болж мөн хэрэглэгддэг байна.

Утопи бол угтаа сэтгэхүйн бүтээл болж байдаг. Иймд түүнийг рационалист (оюуны бүтээл) шинжтэй гэж үзэж бас болох талтай. Гэвч утопид иррациональ янз



бүрийн элемент гарцаагүй шингэмэл байдаг. Үүнд, утопи нь бодит байдалд үндэслэсэн, түүнийг илэрхийлсэн мэдлэг бус, харин бодит байдалд байхгүй, түүгээр зогсохгүй бодит байдлын эсрэг тийм фантази, төсөөлөл, зөгнөл, хүсэл, мөрөөдлийг өөртөө багтааж шингээсэн байдаг.

Боловсролын амьдралд утопи өргөн ашиглагдаж ирсэн түүхтэй ажээ. Тухайлбал ирээдүйн боловсролын тухай Ян Амос Коменский, Жан Жак Руссо нарын үзлийг ихээхэн утопи шинжтэй хэмээн судлаачид үздэг байна. Бас ирээдүйн, тодорхой хэлбэл XXI зууны боловсролын тухай онол, практикийн үзлүүдэд утопи шинж багагүй юм. Үүнийг тааж, зөгнөж биш, харин ямар ч сайн боловсруулсан оюуны бүтээл байлаа гэхэд түүнд зохиогчийн танин мэдэхүйн үр дүн төдийгүй бас хүсэл, сонирхол, хувийн мэдрэмж нь, Товчоор хэлбэл үнэлэмжийн үр дүн заавал агуулагддаг байдлыг иш үндэс болгож байна. Түүнээс гадна XXI зууныг нийгмийн нөхцөл яаж өөрчлөгдөхийг хэн ч урьдчилан яг хэлж чадахгүй биз ээ.

Бүхэлд нь хэлэхэд сургалт, хүмүүжлийн ажлын агуулга, арга барилд утопи хандлага хүчтэй байдаг гэж болно. Тухайлбал тухайн улс орны болон хүн төрөлхтний ирээдүйн тухай, бас манай дэлхийн болон орчлонгийн хувь заяаны тухай шинжлэх ухаан, шашин, урлагийн бүтээл, ёс суртахууны номлол зэрэгт утопи үзэл агуулагдаж, тийм үр дүнгүүд сургалтын маш чухал хэрэглэгдэхүүн ба судлагдахуун болж байдаг билээ.

*Фантази.* Фантази бол сэтгэхүйн ба мэдрэхүйн харилцан уялдааны үр дүнд бий болдог өвөрмөц гоц сэтгэлийн дүрслэл мөн. Утопи, фантази хоёр холбоотой ч яг адил биш юм. Үүнд, утопи бол фантазийг өөртөө агуулж, түүнд тулгуурладаг талтай ч тэр нь дан ганц фантазиар тодорхойлогддоггүй. Түүнээс гадна утопи бол үндсэндээ нийгмийн ирээдүйд холбогддог сэтгэлийн (психик) бүтээл мөн. Тэгвэл фантази бол ганц нийгмийн бодит байдалтай биш, бас байгаль, байгалийн биш (ер бусын далдлаг) зүйлс зэрэгтэй холбогддог. Тийм учраас фантази бол бүтээгч үйл ажиллагааны төрлийн хувьд шинжлэх ухааны, шашны, философийн, урлагийн гэх мэтээр илэрдэг.

Сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаанд фантази өргөн ашиглагддаг билээ. Фантази бүтээлүүд боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөхөд ашиглагддаг төдийгүй хичээлийн судлагдахуун болж байдаг нь ховор биш практик юм. Атом, түүний бүтцийн тухай философи баримтлалын өөрчлөлт, хөгжлийн бүх түүхэнд фантази санаа агуулагдаж ирснийг нэг жишээ болгон дурдаж болно.



Миф (шидэт домог). "Миф" гэдэг грек хэлнээс гаралтай үгийг манайд "домог" хэмээн орчуулдаг явдлыг уг үгний семиотик (тэмдэглэгч) зориулалтыг зөв илэрхийлдэггүй хэмээн зарим судлаачид шүүмжлэлтэйгээр ханддаг. Тийм судлаачид уг нэр томъёог "шидэт домог" хэмээн орчуулсан ажиглагддаг.<sup>14</sup>

Миний хувьд энэ хоёр орчуулгын сүүлчийн хувилбарыг сонгон авсан болно. Энэ нь дараах учир шалтгаантай. "Домог" гэдэг үг бол: "1.эртнээс нааш амаар үе улиран уламжилж ирсэн түүхт үйл явдал, ер бусын үзэгдэл, юмны тухай үлгэр яриа; ийм домогтой юм., үлгэр домог - хоршоо үг; 2.шилжсэн байнга ярьдаг зүйл, улиг болсон зүйл; улиг домог"<sup>15</sup> гэсэн утга бүхий байдаг хэмээн монгол хэлний мэргэжилтэнгүүд тэмдэглэжээ. Харин "миф" гэдэг үгэнд домог гэдэг үгний тодорхой хэсэг агуулагддаг талтай ч гэсэн түүгээр үл хязгаарлагдана. Үүнд, "миф" гэдэг үг бол философи, соёл судлалд онолын ойлголтыг илэрхийлсэн утгатай байдаг.

Миф гэж юу болох талаархи философичдийн тайлбарт мөн ялгаатай талууд ажиглагддагийг энд харгалзах шаардлагагүй байна. Үүнд:

- Марксист-ленинист ном зохиолуудад байдаг мифийн тухай ойлголтын агуулга Орост хэвлэгдэж буй өнөөгийн зарим философийн толь бичигт ч гэсэн хадгалагдаж байна. Тэр ойлголтоор миф бол "эртний нийгмийн ертөнцийг үзэхүй илрэх өвөрмөц хэлбэр мөн. Түүнд ер бусын зүйлийн тухай төсөөлөл байдаг тул тэр нь шашны элементүүдийг агуулдаг. Шинэ ба шинэхэн түүхийн үзэл сурталд олон түмний ухамсарт нөлөө үзүүлэгч янз бүрийн хуурамч төсөөллийг тэмдэглэхэд мифийн тухай ойлголтыг ашигладаг".<sup>16</sup> Ийнхүү эл тайлбарллаар миф бол ямагт сөрөг ач холбогдол бүхий үзэгдэл юм.

- Оросын философич М.Р.Жбанков: миф бол "бодит байдлын бие даасан үзэгдлүүд хэмээн тооцогдогч мэдрэгдэн ажиглагдах дүрүүдийн тусламжтайгаар ертөнцийг бүхэллэг олноор мэдрэн, тайлбарладаг хэлбэр мөн"<sup>17</sup> хэмээн тодорхойлоод хүн төрөлхтний түүхийн эхэн үеүдэд болон орчин үеийн аль алинд мифүүд эерэг, сөрөг өөр өөр ач холбогдолтой байж ирсэн гэсэн үзлийг илэрхийлжээ.

Мифийг эртний нийгмийн хүмүүсийн төдийгүй хүн төрөлхтний түүхийн бүх үеийн танин мэдэхүйд ба үнэлэмжинд, түүгээр зогсохгүй бусад төрлийн ч гэсэн үйлдэлд илэрч хэрэглэгддэгийг нэлээд нухацтай судалсан философичид бол структуралист философийн төлөөлөгчид ажээ. Энэ тухай манай зарим судлаачид өөрсдийн бүтээлдээ нотлон авч үзсэн байдаг. Тухайлбал Ц.Гомбосүрэнгийн



бичсэнээр энд Францын философич Клод Леви-Стросс, Ролан Барт нарын үзлийг онцлон үзэх шаардлагатай юм.<sup>18</sup> Р.Бартын 1957 онд "Мифологиуд" нэртэй хэвлэгдсэн өгүүллүүдийн эмхтгэл бүтээлд хүний үйлдэлд, ер нь нийгмийн нийт амьдралд янз бүрийн миф сөрөг үйлчилгээ үзүүлдэг гэсэн санаа илэрсэн байна. Түүний тайлбараар миф бол юм, санаа, ойлголт аль аль нь биш, харин тэмдэглэх хэлбэр ба арга, товчоор хэлбэл үг мөн (энд дурдаж буй "үг" бол зөвхөн эх хэлний нэгжийн биш, ерөөсөө аливаа семиотик илэрхийллийн нэгжийн утгатай). Эндээс үзвэл Р.Барт мифийг объектив агуулгагүй, зөвхөн субъектив бүтээл гэж үзжээ. Түүний тайлбараар миф бол зөвхөн аман хэллэг байх албагүй бөгөөд бас бичиг, дурсгал, сурвалжлага, кино, спорт, жүжиг, реклам зэргээр хүмүүст хуурамч бодол, дүгнэлт бий болж байвал тэдгээр нь миф мөн.

Ийнхүү францын энэ философичийн үзлээр миф бол хуурамч мэдээллийн тогтолцоо мөн бөгөөд ертөнцийн аливаа юмс миф болох бололцоотой аж.

Гэтэл философийн структурализмыг үндэслэгч гэж мэргэжлийн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн К.Леви-Стросс судалгаагаа гол нь эртний нийгэмд бий болсон мифүүд дээр явуулаад хүмүүсийн сэтгэхүй ба амьдралд миф эерэг чухал үүрэг роль гүйцэтгэж ирсэн хэмээн үндэслэжээ. Тэрээр 1958 онд хэвлүүлсэн "Бүтцийн антропологи" зохиолдоо: миф бол нэгэн төрлийн хэл байдалт нийлмэл зохион байгуулалттай тэмдгийн тогтолцоо мөн. Хүн бол хүрээлэн байгаа ертөнцийн янз бүрийн эсрэг тэсрэг тал ба зөрчилт шинжтэйг танин мэдэж, зөв тайлбарладаг байх ёстой гэсэн санаа мифэд байдаг бөгөөд тэгж танин мэдэх нь хүн, ертөнц хоёрын дунд, хүмүүсийн янз бүрийн бүлгийн хооронд үүссэн тасралтыг засаж, танин мэдэхүйн зохицлыг хангахад чухал ач холбогдолтой хэмээн тайлбарлажээ.

Миф бол логик түвшинд хүрээгүй сул хөгжсөн сэтгэхүйн бүтээл мөн гэж үзэн сурталчилсан францын угсаатны зүйч, философич Л.Леви-Брюлийн үзлийг К.Леви-Строс үл зөвшөөрсөн байна. Тэгээд: хүй нэгдлийн нийгэмд, тухайлбал шинэ чулуун зэвсгийн үед ноёрхож байсан сэтгэхүйн үйл ажиллагааны гол гол онцлог бол уламжлалт нийгмүүдийн оюуны төрхөд хадгалагдаж ирсэн төдийгүй орчин үеийн сэтгэхүйн эд эсэнд шинжлэх ухааны сэтгэхүйн хэлбэрүүдтэй зэрэгцэн байдаг гэж К.Леви-Строс нотлоод, эртний тийм сэтгэхүйг "зэрлэг сэтгэхүй" гэж нэрлэжээ.

Гэхдээ эртний мифологи (зэрлэг) сэтгэхүй, орчин үеийн логик сэтгэхүй хоёр юуг оюун дүгнэлтийн үндэс болгодоггоороо бие биеэсээ ялгаатай байдгийг К.Леви-Строс



илрүүлсэн юм. Үүнд, мифологи сэтгэхүй дэх дүгнэлт гаргах үндэслэгээ нь орчин үеийн хүний сэтгэхүйн үүднээс авч үзвэл хангалттай биш, гол биш, тохиолдлын шинжтэй нь ховоргүй байж, түүний улмаас мифологи сэтгэхүйн логикт зууч (бриколлаж) шаардагддаг гэж тэрээр илрүүлэн тайлбарласан байна. Бриколлаж бол тодорхой зүйлд тухайн нутаг, овгийнхон анхаарлаа хандуулдаг байдал нь бэлгэдлийг (символыг) ашиглахтай уялддагийг заагч мөн. Бэлгэдэл бол мэдрэхүйн тодорхой дүр, хийсвэр ойголт хоёрын дундах завсрын логик статус болж өгдөг. Өөрөөр хэлбэл, аливаа бэлгэдэл бол сэтгэхүйн тодорхой нэгжийн буюу завсрын үүрэгтэй байдаг. Улмаар тодорхой бүлэг бэлгэдэл дэх утгын талбаруудыг нэгтгэн холбодог кодууд нь сэтгэхүйд категориудын ач холбогдолтой байдаг гэж К.Леви-Строс үзсэн байна.

Ийнхүү К.Леви-Стросын үзлээр миф бол сэтгэхүйн зөвхөн субъектив бүтээл төдий биш, харин объектив тодорхой санаа илэрхийлдэг бөгөөд тийм объектив санаа нь бэлгэдлийн агуулга болж батажсан байдаг байна.

Энд нэг зүйлийг зориуд тэмдэглэхэд К.Леви-Строс бол зөвхөн эртний нийгмийн мифүүдийг авч үзсэн ба гэхдээ уг судалгаанаасаа хийсэн дүгнэлтүүд нь орчин үеийн мифийн тодорхой төрөлд, тодорхой илрэлд хүчинтэй байж чадахаар юм. Ийм дүгнэлтийг энд хийхдээ мифийн тухай өөр өөр үзлийг харьцуулан авч үзсэн байдалдаа тулгуурласан болно.

Миф гэж юу болох, тухайн хүний үйлдэлд болон нийт нийгмийн амьдралд миф ямар ач холбогдолтой байдаг талаархи дээр дурдсан маягийн өөр өөр үзлийг харьцуулан авч үзсэн маань дараахь ерөнхий дүгнэлт хийх бололцоо олгож байна. Үүнд, миф (шидэт домог) бол бодит байдлын тодорхой үзэгдлийн талаархи өөдрөг дэвэргэн юм уу зориудын бэртэгчин хуурамч санааг мэдрэхүйн дүрээр дамжуулан илэрхийлэхүй мөн. Ийм учраас хүмүүсийн үйлдэлд, улмаар нийгмийн нийт амьдралд зарим миф эерэг, зарим миф сөрөг ач холбогдол үзүүлдэг ажээ.

Миф ийм хоёрдмол роль бүхий байдаг нь боловсролын практикт шууд хамаарч байдаг. Энэ нь боловсролын үйл ажиллагааг зохион байгуулж буй практик, боловсролын сургалт, хүмүүжлийн ажлын агуулга аль алинд холбогдоно. Тухайлбал, монголын социализмын жилүүдийн нийгэм, хүмүүнлэгийн салбар дахь сургалтанд: "Монголд социализмын бүрэн ялалтыг хангах" гэдэг миф маш чухал онолын агуулгат хэсэг болж байсан бол эдүгээгийн манай сургалтанд Монголын өнөөгийн бодит байдлыг "хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгэм" мөн гэдэг мифийг сурталчилж



байна. Угтаа 1992 онд баталсан Монгол улсын үндсэн хуульд томъёологдсон энэ үндэслэлийг улс төрийн онолын зорилтын үүднээс зөвшөөрч болох авч практикт түүнийг яг хэрэгжиж байгаа мэт сурталчлах нь миф мөн. Зарим багш өөрийн заадаг хичээлийг бусдын хичээлээс "илүү хүнд", "илүү ач холбогдолтой" гэх мэт мифийг зохион байгуулж байдгийг бас нэг жишээ болгон дурдаж болох юм.

Үүний зэрэгцээ эерэг утопи, эерэг фантазад үндэслэсэн эерэг мифүүд хүн төрөлхтний түүхийн бүх үе дэх боловсролын онол, практикт өргөн ашиглагдаж, боловсролын хөгжилд чухал нөлөө үзүүлж иржээ. Жишээ нь: атом, түүний бүтцийн тухай философи, шинжлэх ухааны мэдлэг; амьдралын тухай биологи онолууд; нийгмийн шударга ёсны тухай онолууд зэрэг нь хүн төрөлхтөний нийт үйл ажиллагаанд холбогдохоороо миф мөн ч гэсэн түүний тодорхой нөхцөлд хүчинтэй байж чадаж иржээ.

Ийнхүү боловсрол бол танин мэдэхүй мөнийхөө хувьд рациональ (оюунлаг) ба иррациональ (ухамсарт биш сэтгэлийн), онолын ба мифологийн, зайлшгүй ба тохиолдлын, өнөөгийн ба ирээдүйн, улс орныхоо ба дэлхий дахины, сургах ба сурахын, хүмүүжүүлэх ба хүмүүжихийн, субъектийн ба объектийн нэн олон янзын талуудын харилцан уялдааны үр дүн, тийм үр дүн нь үйлдэлд ухамсартайгаар хэрэглэгдэх үйл явц мөн.

#### Резюме

Автор данной работы исходит из того, что образование как важный социальный институт является своего рода познанием и оно предполагает элементы как рационального, так и иррационального. Причём, по её мнению, в образовании рациональные и иррациональные стороны находятся не в иерархическом, а во взаимообуславливающем, взаимодополняющем отношении.

#### НОМ ЗҮЙ

1. См. об этом: Б.С.Гершунский. Философия образования для XXI века (в поисках практико- ориентированных образовательных концепций). М.,1998, Глава 1, §1-4 (с.34-76)
2. Үүнийг нотлох агуулга бүхий зарим сурах бичгийг жишээ болгон дурдахад: Марксист-ленинист философи. Диалектик материализм. Орос хэлнээс



- орчуулсан хэвлэл. УБ., 1971, XI бүлэг; Марксист-ленинист философийн үндсүүд. Дахин боловсруулсан IV хэвлэл. Орос хэлнээс орчуулав. УБ., 1982, VIII бүлэг.
3. К.Маркс.Фейербахын тухай сэдвүүд.-К.Маркс,Ф.Энгельс.Түүвэр зохиол.1-р боть.УБ.,1969, 2 дахь тал
  4. Мөн тэнд, 1 дэх тал
  5. Ф.Энгельс.Байгалийн диалектик. УБ.,1986, 194-204 дэх талд энэ тухай үзнэ үү.
  6. Диалектик, түүхийн материализмын дээж бичиг.УБ.,1970 номын 205 дах талд энэ тухай үзнэ үү.
  7. Энэ тухай: С.Норовсамбуу.Логик.Хоёрдах удаагийн хэвлэл.УБ.,1977,7-8 талд үзнэ үү.
  8. И.Г.Гаманы үзлийг тайлбарлахдаа миний ашигласан бүтээл: The Cambridge Dictionary of Philosophy. Cambridge, 1995, pp. 308-309
  9. Сэтгэхүйн агуулга бодит байдлаар биш, харин хэлээр нөхцөлддөг тухай В.фон.Гумбольдтын үзлийг илэрхийлэхдээ миний ашигласан бүтээл: Вильгельм фон Гумбольдт. Язык и философия культуры.Сборник.М.,1985.
  - 10.Ф.Т.Якобигийн иррационалист үзлийг тайлбарласан монгол зохиогчийн өгүүллэгийг дурдахад: Ц.Гомбосүрэн. Иррационализмын анхны төлөөлөгчид. - Эрх чөлөө ба философи.Философи, нийгмийн сэтгэлгээний бүтээлийн цуврал эмхтгэл. VI.УБ.,2000,11-12 дахь тал
  - 11.А.Шопенгауэрийн иррационализмын гол агуулгатай монгол хэл дээр танилцъя гэвэл: мөн тэнд, 12-15 дахь талд үзнэ үү.
  - 12.Н.Карлов. Преобразования образования.-Вопросы философии.М., 1998, №11, с.16
  - 13.Философия, культура, образование. Материалы "круглого стола".-Вопросы философии.М.,1997, №8, с.18
  - 14.Философи.Сурах бичиг. УБ., 2002. Удиртгал бүлэг, 2§-д энэ тухай үзнэ үү.
  - 15.Я.Цэвэл.Монгол хэлний товч тайлбар толь.УБ.,1966,199 дэх тал
  - 16.Л.Н.Столович.Мифология.-Философский словарь. Под редакцией И.Т.Фролова. Издание седьмое, переработанное и дополненное. М., 2001, с.335
  - 17.М.Р.Жбанков. Миф. -Всемирная энциклопедия. Философия. М.-АСТ.-Мн-Харвест,2001,с.643
  - 18.Ц.Гомбосүрэн.Структурализм ба эдүгээ үеийн түрүү философидолт (постструктурализм, постмодернизм). Нэмэлт оруулж засварласан 2 дахь хэвлэл. УБ., 2006, II бүлэг, 2§,3§-д энэ тухай үзнэ үү.